



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2024 оны 01 сарын 11 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.16 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 379 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтыг хүчингүй болгосугай.

2.“Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн зохион байгуулалтын бүтцийн схем, орон тооны дээд хязгаарт багтаан албан тушаалын жагсаалт баталж үйл ажиллагаа явуулахыг Гүйцэтгэх захирал (Б.Отгонсүх)-д даалгасугай.

3.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

123007542

1-r huraldaan.docx